



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/19

Чингис хот

Мэргэжлийн анги байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалт, Монгол улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 75 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/373 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшиг ослын үед хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гамшиг ослын бүсээс нүүлгэн шилжүүлэх, тусламж үзүүлэх, тэдний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах зорилго бүхий мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон дэд бүлгүүдийг тус тус шинэчлэн байгуулсугай.

2. Нийгмийн хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг Нэгдүгээр хавсралтаар, Хүүхэд хамгаалал, боловсролын бүлгийн бүрэлдэхүүнийг Хоёрдугаар хавсралтаар, Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлгийн бүрэлдэхүүнийг Гуравдугаар хавсралтаар, Сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн бүрэлдэхүүнийг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг мэргэжлийн ангийн дарга /Л.Батжаргал/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/04 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР